



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 578

Улаанбаатар хот

Сургалтад оролцуулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.11 дэх заалт, “Монголбанкны сургалтын журам”-ын 3.1, 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хэлтсийн нөөцийн мэргэжилтэн Э.Анхланг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 15-ны өдрүүдэд Дэлхийн банкнаас (RAMP) зохион байгуулагдах “Gold as an Asset Class for Reserves Managers” сэдэвт сургалтад оролцуулсугай.

2. Э.Анхлангийн ирэх, очих онгоцны тийз, зочид буудлын зардлыг зохион байгуулагч талаас, унаа, даатгал, томилолтын зардлыг төсвөөс урьдчилан олгож, баримтыг нь үндэслэн Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын гадаад сургалтын зардлаас эргэж тооцоо хийхийг Тамгын газар (Ж.Батхуяг), Тайлан бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН